

## ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ӨМНӨТГӨЛ ҮГ

1990-ээд оноос манай хүрээлэнгийн хятад судлаачид эрхлэн БНХАУ-ын шинэтгэл, нээлттэй гадаад бодлого, түүх, соёл, Монгол-Хятадын харилцааны холбогдолтой судалгааны цөөн биш ном бүтээл хэвлэн нийтлүүлж буйн дээр “Олон улс судлал” хэмээх тогтмол хэвлэл /сэтгүүл/-д олон арван өгүүлэл нийтлэгдэж уншигч өргөн олон түмний хүсэл сонирхолд ихэд нийцэж байгаа билээ. Гэвч хоёр орны харилцаа улам бүр өргөжин тэлж буй өнөө үед хятад хэл, түүх, соёлыг сонирхон судлагчдын тоо жилээс жилд нэмэгдсээр байна. Ажил төрөл, бизнесийн шугамаар Хятад улстай холбоотой байгууллага хүмүүсийн тоо ч олширч байна. Эдүгээ албан бус мэдээгээр хятад хэлийг манай орны 25 их, дээд сургууль, 14 бага, дунд сургуульд зааж буй мэдээлэл байна. Иймд эрдэм шинжилгээ, сургалт, нийгмийн аль ч талаас авч үзсэн эрдэм шинжилгээ-танин мэдэхүйн чиглэлтэй хятад судлалын дагнасан тогтмол хэвлэл /сэтгүүл/ гаргах бодит эрэлт хэрэгцээ их байгаа юм. Эл байдлыг харгалзан Монгол улс дахь хятад судлалын гол байгууллага болох ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс “Өнөөгийн Хятад” сэтгүүлийг эрхлэн гаргаж анхны дугаарыг та бүхэнд өргөн толилуулахад нэн таатай байна.

Манай найрамдалт их хөрш - БНХАУ-ын тухай өргөн мэдээлэл, судалгааны сонирхолтой материал орсон энэ сэтгүүл нь манай улсад Хятад орныг танилцуулж, найрамдал нөхөрлөлийг бэхжүүлэх зорилго бүхий анхны бие даасан хэвлэл гэдгээрээ онцлог юм.

Бидний өмнөд их хөрш - Бүгд Найрамдах Хятад Ард Улсыг сонирхож судалдаг хэн бүхэнд энэ сэтгүүл хэрэгтэй байх болно гэдэгт миний бие итгэлтэй байна. Энэ ялдамд уг сэтгүүлийг хэвлэн нийтлэхийг бүх талаар дэмжиж, ивээн тэтгэсэн БНХАУ-аас манай улсад суугаа Элчин Сайдын Яам, ялангуяа Элчин сайд ноён Гао Шумао гуайд гүн талархлаа илэрхийлье.

Олон улс судлалын хүрээлэнгийн захирал,  
сэтгүүлийн ерөнхий эрхлэгч,  
доктор, профессор **Лувсангийн Хайсандай**

